

ЭРДЭМТЭЙ ХҮНИЙ ТАЛААРХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Б.Жадамба^{1*}, Л.Эрдэнэчимэг, МУБИС

Abstract

This study is the attempt to identify why researchers have regarded the indigenous people as ‘genuine intellectuals,’ to analyze the key criteria and indicators of ‘being recognized as ‘genuine intellectuals’ and to draw some conclusions and further suggestions. The research findings revealed that the main criteria of the ‘genuine intellectuals’ within a community might have touched those such as the ethical behaviors, actions, styles, and life science skills they have showed and demonstrated within their community. Furthermore, the study discovered that the static and cognitive aspects of ‘getting highly educated’ have been taken for granted while the dynamic and metacognitive aspects were the least concerned in education. The study concluded that the existing core principles of getting highly educated in any sciences in school environment need to be transformed into the fundamental principles of being self-cultivated in the metacognitive (dynamic) traits of these sciences.

Түлхүүр үг

Эрдэм, үйл (ёс эрдэм), эрдэм чанар (өөрөө болсон ёсыг буюу үйлийг журамлан дагахуй), эв эе (эв дүй), боломж, тогтвортой хөгжихүйц боловсрол

Судалгааны дизайн

Дани Улсын ДАНИДА¹-гийн дэмжлэгтэйгээр Монголын БДБХДН²-ийн хэрэгжүүлж буй “Монголын уламжлалт соёлд түшиглэн орон нутгийн иргэний нийгмийн чадамжийг дээшлүүлэх” төсөлд хамрагдсан хорин нэгэн аймгийн тавин долоон салбар оршин буй хөдөөгийн сумдын (Зураг 1) хүрээнд энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн.

Зураг 1

Судалгаанд хамрагдсан сум, орон нутгийн тархац



Судалгааны арга, үр дүн

Судалгааг хийхдээ дараах арга зүйг ашиглав. Нэгдүгээрт, салбар бүрээс ирсэн оролцогчдыг 4-6 гишүүнтэй баг болгон хувааж, багийн гишүүн тус бүрээс “Танай орон нутагт хэн гэдэг эрдэмтэй хүн байна вэ?, Яагаад та түүнийг

эрдэмтэй гэж үзэж байна вэ?, Эрдэмтэй хүний шалгуурыг та юу гэж үзэж байна вэ?” гэсэн асуулгын дагуу хариулт авав. Хоёрдугаарт, баг дотроо гишүүн бүр өөр өөрийн дээрх гурван асуултын дагуу бэлтгэсэн зүйлээ танилцуулан, хоорондоо ярилцаад нэг “эрдэмтэй хүн” дээр төвлөрч, гишүүн бүр саналаа нэмэрлэнэ. Эцэст нь, баг бүр бусад багт эрдэмтэй хүнийхээ тухай танилцуулсан. Ийнхүү танилцуулсны дараа тухайн бүсэд оролцсон нийт хүмүүс “Эрдэмтэй хүн”-ий талаарх гурван асуултын хүрээнд дахин ярилцаж, бүс тус бүрээс 4-6 эрдэмтэй гэж үзсэн хүнийг буюу судалгаанд оролцогчид (1 дүгээр зурагт үзүүлсэн) таван бүсээс бүгд 23 эрдэмтэй хүнийг тодруулсан болно.

Судалгаа Монгол Улсын говь, хангай, тал хээрийн бүх бүсийн хүрээнд өрнөсөн юм. Судалгаанд нийт таван зуун гучин таван хүн хамрагдсан бөгөөд түүний 95% нь дээд боловсролтой, эрэгтэй 171, эмэгтэй 364 байна. Насны хувьд 40-55 байсан, тэдний 80% нь багш, 13% нь тамгын газрын ажилтнууд, 7% нь жолооч зэрэг туслах ажилтан байв.

Оролцогчдоос “Танай орон нутагт хэн гэдэг эрдэмтэй хүн байна вэ?, Яагаад, та түүнийг эрдэмтэй гэж үзэж байна вэ?, Эрдэмтэй хүний шалгуур үзүүлэлтийг та юу гэж үзэж байна вэ?” гэсэн асуултаар асуулга хийгээд ярилцлагын судалгааг авч дараах байдлаар задлан шинжилж, харьцуулж, нэгтгэн дүгнэсэн болно. Эрдэмтэй хүний талаарх ерөнхий мэдээлэл Судалгааны дүнд сонгон авсан эрдэмтэй хэмээн

*✉ jadambaabadrakh@msue.edu.mn

¹ДАНИДА - Danish International development Agency

²БДБХДН - Бага, дунд боловсролын хөгжлийг дэмжих нийгэмлэг

тодорсон 23 хүний хамгийн залуу нь 37 настай буюу судалгаанд хамрагдагсдын 4%-ийг эзэлж байгаа бол, 14 нь 60-аас дээш настай буюу хувиар илэрхийлбэл, 61%-ийг эзэлж байна. (График 1). Мөн тэдний 18 нь эрэгтэй, 5 нь эмэгтэй хүн байна (График 2).

График 1

Эрдэмтэй хүмүүсийн насны байдал





График 2


Эрдэмтэй хүмүүсийн хүйсийн байдал



Мөн дээрх эрдэмтэй хүмүүсийг боловсролын түвшнээр нь ангилан үзвэл, тэдний 43% нь сургуульд сураагүй, 22% нь бага, 9% нь бүрэн дунд, 26% нь дээд боловсролтой байна (График 3).

График 3

Эрдэмтэй хүмүүсийн боловсролын түвшин



1. Яагаад эрдэмтэй гэсэн талаарх баримт


Судалгаанд хамрагдсан хүмүүс *Яагаад эрдэмтэй гэж үзэж байна вэ?* гэсэн асуултад хүн бүр өөр өөрийнхөөрөө олон янзаар хариулж байсан. Гэхдээ тэдний дотроос амь ухаантай, өөрөө ажлын байраа олдог, амьжиргаагаа аваад явчихдаг, нутаг орондоо нэр хүндтэй, билиг авьяастай, гарын уртай, малч, ажилсаг хөдөлмөрч, аливааг амархан сурдаг, бусдыг үлгэрлэн дагуулж, сургадаг зэрэг ерөнхий шинжүүд тодорч байна. Тэдний хариултаас зарим нэг эрдэмтэй хэмээн тодорсон хүнийг жишээлж үзье.

- а. “Баянхонгор аймгийн Баянбулаг (төвийн бүс) сумын малчин, маарамба Ч.Я. 7-р анги төгсөөд Ховдын ХАА-н техникумыг малын бага эмч мэргэжлээр төгссөн. Өөрийн сонирхлоор хүний биеийн анатоми судалсан, судас барьж оношилж, ургамлаар эм тан хийж эмчилдэг. Дорно дахины маарамбын эрдмээс суралцах явцдаа энэтхэг, төвөдийн гүн ухаан дуун ухааныг сонирхон бие дааж судалсан. Үүнийхээ үндсэн дээр зөгнөлт роман нэг, яруу найргийн түүвэр нэгийг хэвлүүлсэн. Мөн хар зураг маш сайн зурдаг. “Цаглашгүй эрчис” нэртэй уран зургийн урсгал гаргаж, энэ урсгалаараа альбом гаргасан байна.
- б. “Дорноговь аймгийн Хөвсгөл (говийн бүс) сумын харьяа, өндөр настан Ц.Д. Энэ хүн хоёр нүд нь хардаггүй сохор боловч хүний дуу хоолойгоор шууд таньж овог нэрээр нь хэлдэг, үнээ саахдаа тугал эх хоёрыг илж үзээд таньдаг, утас зүүг амаараа сүвлэдэг, тэмээний ноосон утсыг имэрч үзээд өнгийг нь мэддэг, мөнгийг имэрч тоолдог.
- в. “Сүхбаатарын Асгат сумын харьяат Ш.Г.-ямар нэг сургууль төгсөөгүй боловч өөрийн гарын ур чадвараар уран зураг зурдаг, сийлбэр хийдэг, гэрийн мод, авдар сав хээлдэг, сандал, ширээ, гэрийн тооно, хаалга хийдэг, байшин барилга барьдаг, цаасан хайчилбар хийдэг, багшийн мэргэжилгүй ч зураг, технологийн багшаар ажиллаж байсан” зэрэг болно.

2. Эрдэмтэй хүний шалгуур, үзүүлэлтийн талаарх баримт

Судалгаанд хамрагдсан хүмүүст “Эрдэмтэй хүн”-ий шалгуур, үзүүлэлтийг гаргана уу? гэсэн асуултын хариуг нэгтгэн үзвэл, эв дүйтэй, нийтэч, нэр хүнд сайтай, хөдөлмөрч, аливааг амархан сурдаг, авьяастай, ой тогтоолт сэтгэлгээ сайтай гэх зэрэг шинжүүд тодорсон (График 4) бөгөөд тэдний хамгийн олон удаа давтагдсан нь “Нийтэч, олондоо нэр хүндтэй” байна.

График 4
Эрдэмтэй хүний шалгуур үзүүлэлтийн давтамж



Хэлэлцүүлэг


Нэгэн зүйл: “Эрдэмтэй хүн” гэдэг нь “Боловсролтой хүн” гэдгээс тэс өөр ойлголт байна. Учир нь, “Эрдэмтэй хүн” бол өөрөө юмыг сурсан, сурдаг, ажлын байраа олдог, бусдад тусалдаг, орон нутагтаа нэр хүндтэй, ихэвчлэн сургуульд сурч мэргэжил эзэмшээгүй, байгалиас заяасан авьяастай, түүнийгээ бие дааж хөгжүүлсэн, ихэнх нь 4-7-р ангийн боловсролтой, амьдралын хар ухаантай, ажилсаг, оролдлоготой, ард олондоо хүндлэгдсэн, жирийн малчин, ажилчин, бусдад үлгэр дуурайлтай, манлайлах чадвартай, бусдад эергээр нөлөөлдөг, тууштай, өөрийн гэсэн үзэл бодолтой, сурсан мэдсэн зүйлээ бусдад зааж сургаж, зөвлөдөг, эв эеийг хичээн баримталдаг хүмүүс байна (Зураг 1, 2, 3). Үүнээс эрдэмтэй хүний үзүүлэлтийг “үйл (ёс эрдэм), эрдэм чанар (арга барил), эв эе (эв дүй)-ээр илэрхийлэх боломжтой гэж үзэж болох байна.

Харин өнөөдөр бид чадамж сайтай, тухайлбал, мэдлэг, чадвар, хандлага сайтай хүнийг боловсролтой хүн гэж ойлгож байна. Энэ нь боловсролтой хүний үзүүлэлт нь чадамж, түүний бүрэлдүүлбэр болох мэдлэг, чадвар, хандлага гэсэн үг. Үүнийг дээрх “эрдэмтэй хүн”-ий талаарх ойлголт, үзүүлэлттэй харьцуулбал, Монгол улсад

өнөөдөр өндөр боловсролтой хүн хэрэгтэй байна уу?, эсвэл, эрдэмтэй/эрдэм боловсролтой хүн хэрэгтэй байна уу? гэдэг асуултад хариу өгөх боломж гарч байна. Өөрөөр хэлбэл, бид өнөөдөр Монгол оронд өндөр боловсролтой хүнээсээ илүү эрдэмтэй хүн хэрэгтэй байна гэсэн хариултыг санал болгож байна.

Нэгэн зүйл: Хүний “эрдэм боловсрол” бол түүний хөгжлийн хос эхлэл. Хөгжил нь үйл ба үр дүнгийн нэгдэц нэгэн болохыг тооцвол, түүнийг 6-р зурагт үзүүлсэн байдлаар дүрсэлж болно. Чадамж нь мэдлэг, чадвар, хандлага гэсэн гурван үзүүлэлтийн нийлэмжээр тодорхойлогддог байна. Харин эрдэм талаасаа, хүний хөгжлийн хэмжүүр бол түүний боломж. Боломж нь мөн чанарын ёс буюу өөрөө болсон ёс болох үйл, арга барил буюу журамлан дагах, эв дүй гэсэн гурван үзүүлэлтийн нэгдцээр илэрхийлдэг байна (Зураг 2).

Зураг 2
Эрдэмтэй хийгээд боловсролтой хүний хэмжүүр



Нэгэн зүйл: Дэмчигдорж (1995, х.54), “Эрдэм хэмээгч даруй өөрөө болсон ёс журмыг дагах нь мөн болой. Бас эрдэм чанар хэмээнэ”, “Эдийн чанар эвэндээ, эрдмийн чанар аргандаа”, “Эрхмийн дээд эх, эрдмийн дээд эв” гэдгийг тус тус тооцвол, 6 дугаар зурагт үзүүлсэн эрдэмтэй хүний үйл, эрдэм чанар, эв эе гэсэн үзүүлэлтэд харгалзах шалгуурыг дараах байдлаар томъёолж болох юм. (Хүснэгт 1).

Хүснэгт 1
Эрдмийн шалгуур, үзүүлэлт

	Шалгуур	Үзүүлэлт	Хэмжээс “сайн, дунд, муу”
ЭРДЭМ	Үйл (ёс эрдэм)	Хүний хэрэг явдалд төв дунджаар ханддаг байдал	
		Байгаль, нийгмийн юмс, үзэгдлийн зүй тогтлыг буюу жамыг даган нийцдэг байдал	
		Олон түмний заншсан хэв суртал, хүний мөрдөх журам, заншил, зайн үйл, хууль зүйг дагадаг байдал	
	Арга барил (Эрдэм чанар)	Үгээр нь бус үйлээр нь шинждэг байдал	
		Үйлийн буюу үйл дээрх судалгаа эрхэлдэг байдал Үйлийн явцдаа суралцдаг байдал	
	Эв эе (эв дүй)	Бусадтай дотно харьцаатай байдал Бусадтай таарамжтай байдал	
Юмыг хийх арга ухаан, эв дүй			

Эрдмийн шалгуур үзүүлэлтийг бид “хүн ёс дагана, нохой яс дагана”, “номын ёсыг мэдвэл номхон төлөв болно, төрийн ёсыг мэдвэл төлөв төвшин болно”, “амьдралын түлхүүр ажил, ажлын түлхүүр арга”, “Эвлэвэл бүтнэ, ховолол гутна”, “Үгээр нь бус, үйлээр нь шинж” зэргээс үйл гэдэг нь ёс, эрдэм, эрдмийн чанар гэдэг бол “арга”, тухайлбал, аливаа зүйлийн өөрөө болсон ёс болох үйлийг журамлан дагахуй”, эв эе гэдэг нь “бүтээх чадвар, бас эв эе” гэж үзэж болно. Тиймийн учир эрдэмтэй хүний “үйлийн буюу ёс зүй”-н шалгуурыг “Хүний хэрэг явдалд төв дунджаар ханддаг байдал”, “Байгаль, нийгмийн юмс, үзэгдлийн зүй тогтлыг буюу жамыг даган нийцдэг байдал”, “Олон түмний заншсан хэв суртал, хүний мөрдөх журам, заншил, зан үйл, хууль зүйг дагадаг байдал”, үйлийг журамлан дагахуйн шалгуурыг “Үгээр нь бус үйлээр нь шинждэг байдал”, “Үйлийн буюу үйл дээрх судалгаа эрхэлдэг байдал”, “Үйлийн явцдаа суралцдаг байдал”, эв эеийн шалгуурыг “Бусадтай дотно харьцаатай байдал”, “Бусадтай таарамжтай байдал”, “Юмыг хийх арга ухаан, эв дүй” гэж тус тус тодорхойлсон. Харин хэмжээсийг нь “сайтай, тааруухан, муутай” байж болно гэж үзлээ (Хүснэгт 1).

Дүгнэлт

Эрдэмтэй хүн, түүний шалгуур үзүүлэлтийн талаар хөдөө, орон нутгийн багш, сургуулийн удирдлага, тамгын газрын болон сургуулийн ажилтнуудаас авсан судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Өнөөдөр Монгол Улсад “өндөр боловсролтой” хүмүүсээс илүү эрдэмтэй иргэн хэрэгтэй байна. Иймийн учир, өнөөгийн бүх шатны боловсролын зорилго, зорилт, хөтөлбөр, арга зүй, үнэлгээг эргэн харж, суралцагчдыг эрдэм чанарыг боловсруулж, өөрсдөө өөрийн боломжид түшиглэсэн ёс зүйтэй, эрдэм чанартай, эв дүйтэй болох чиглэлээр хувирган сайжруулах шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүс үндсэндээ өөрөө аливааг сурч, ажлын байраа гарган, амьдрал ахуйгаа авч явдаг, олны дунд нэр хүндтэй, бусдад тусалж, дэмждэг хүнийг “Эрдэмтэй хүн” хэмээн үзэж байна.

Судалгааны “Яагаад эрдэмтэй гэж байна вэ?” гэдэг асуултын хариулт болон шалгуур үзүүлэлтийг 1 дүгээр хүснэгтээс эрдэмтэй хүн гэдгийг “Тогтвортой хөгжихүйц боловсролтой” нэгэн (Б.Ж.) хэмээн үзэж болох талтай байна. Энэ нь “Тогтвортой хөгжихүйц боловсрол” гэдэг нь

хүмүүний “Эрдэмтэй” болсон байдал гэж ойлгож болохоор байна.

Хүний эрдмийг ёс зүй (үйл), эрдэм чанар (журамлан дагах), эв эе (эв дүй), түүнд харгалзах “сайн, дунд, муу” гэсэн шалгуурын дагуу тодорхойлж болно.

Энэ цаг үед хэрэгжиж буй “Тогтвортой хөгжихүйц боловсрол”-ын талаарх төсөл хөтөлбөрүүд зорилго зорилтоо өөрсдийн “зорилтот бүлэг”-ээ эрдэмтэй болгохуйц болгон сайжруулах шаардлагатай байна зэрэг болно.

Ашигласан материал

- Дашдорж, Ж., Ринчэнсамбуу, Г. (2008). *Монгол ардын зүйр цэцэн үг*. Улаанбаатар
- Дэмчигдорж, Ч. (1995). *Эрдэнэт толь хэмээх шастар оршивой*. Улаанбаатар
- Жадамба, Б. (2016). *Үйлийн судалгаа Квант онол*. Улаанбаатар
- Жадамба, Б., Жонни Балтзерсен. (2016). *Мэдээлэл 2016*. Улаанбаатар
- Нямбуу, Х. (1992). *Монголын зан заншлын их тайлбар толь*. Улаанбаатар
- Сампилдэндэв, Х. (1987). *Монгол ардын зан үйлийн аман зохиол*. Улаанбаатар
- Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар
- Цэрэнсодном, Д. (2011). *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Улаанбаатар
- Эрдэнэ-Очир, Г. (1979). *Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйн уламжлалаас*. Улаанбаатар